

ЭНЭТХЭГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ, ХӨГЖИЛ

Д.Отгончимэг¹

Энэ оны 10 дугаар сарын нэгний өдөр Энэтхэгийн үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний гарамгай удирдагч, тусгаар тогтнолын төлөө тэмцэгч Мохандас Карамчанд Гандийн 140 насны ой болсон билээ. Сатьяграх буюу хүч үл хэрэглэх тухай Гандийн онол бодит амьдралд хэрэгжиж 1947 онд Энэтхэг улс 200 гаруй жилийн Английн ноёрхлоос салж тусгаар тогтнолоо олсон түүхтэй. Энэхүү онолын ач холбогдлыг үнэлэн 2007 онд НҮБ-аас Гандийн төрсөн өдрийг хүч үл хэрэглэх өдөр болгон тунхаглаж дэлхий нийтээр тэмдэглэх болсон бөгөөд манай сургуулийн хамт олон 2 дахь жилдээ тэмдэглэн багш, оюутнууд Энэтхэг орны талаарх мэдлэгээ гүнгийрүүлээ. Энэхүү өгүүлэлдээ Энэтхэгийн эдийн засгийн өсөлт, хөгжлийн асуудлыг тусгаар тогтнолоо олсон үеэс эхлэн хөгжлийн үе шатаар ололт амжилтыг нь нэгтгэн дүгнэхийн зэрэгцээ ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг харуулахын хичээсэн болно.

Энэтхэг улсын тусгаар тогтнолын нэг гол асуудал нь эдийн засгийн тусгаар тогтнол, олон зууны хоцрогдлыг гэтлэн давах асуудал байсан юм. Английн эдийн засгийн ноёрхол нь улс орныг цөлмөн ард түмний хувьд давж дийлшгүй хүнд ачаа байсныг Махатма Ганди эсэргүүцэн 1930 онд давсны онц эрхийг эсэргүүцэн тэнгэсийн эргийн дагуу алдарт аяллаа эхэлж байсан түүхтэй. Энэ нь ядуучуудад хүндээр тусч байсан давсны татварыг эсэргүүцэх явдлаар эхэлж улмаар эдийн засгийн дарамт болсон аливаа хууль зарлигийг эсэргүүцсэн хөдөлгөөн болж өргөжсөн² түүхтэй.

“Энэтхэг нь 700 мянган энэтхэг тосгон гэж ойлгогддогийн хувьд нийгэм, ёс суртахуун, эдийн засгийн тусгаар тогтнолоо бас олж авбал зохино”³ гэж Ганди үзэж байжээ. Хүч үл хэрэглэх Махатма Гандийн онолыг баримтлан Энэтхэг орон тусгаар тогтнолоо олж тухайн үеийн улс төрийн бодлогын хоёр туйлаас ангид, бие даах, эвсэлд үл нэгдэх бодлого баримтлан улс орноо үйлдвэржүүлж эдийн засгийн өндөр өсөлтийг ханган хөгжил дэвшилд хүрсэн нь дэлхий нийтийн анхаарлыг татах болсон билээ.

1950-аас 1991 он хүртэлх хугацаанд үндэсний орлого нь 4 илүү дахин, аж үйлдвэрлэл 8 дахин, ургац хураалт 3 дахин өсжээ. 1951-1956 оны анхны төлөвлөгөө нь хөдөө аж ахуйн хөгжилд голлон чиглэж тээвэр, эрчим хүчний үйлдвэрлэлийг хөгжүүлж, хөдөө орон нутагт эрчим хүчийг нийлүүлэх замаар хүн амын орлогыг нэмэгдүүлэх зорилготой байлаа. Аж үйлдвэрийн үндэс суурийг 2 дахь таван жилийн төлөвлөгөөнөөс л эхлэн тавьсан байна. Ингэхдээ эдийн засгийн тусгаар тогтнолоо хамгаалах, үндэсний үйлдвэрлэлээ дэмжих үүднээс импортыг орлох загварыг сонгон аж үйлдвэржүүлэх бодлогыг хэрэгжүүлсэн бөгөөд үүний үр дүнд хар ба өнгөт төмөрлөг, машины үйлдвэрлэл, эрчим хүч, батлан хамгаалах, төмөр зам, агаар усан замын тээвэр, холбоо, олборлох зэрэг үйлдвэрийн суурь салбаруудын үндсийг тавьж чадсан юм.

Энэтхэг орны нийгэм эдийн засгийн хөгжлийг 1991 оноос өмнөх, хойшхи үе гэж хуваан авч үздэг талтай. Учир нь 1991 оныг хүртэлх хугацаанд хагас төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай явж ирсэн бөгөөд аж үйлдвэрийн газрууд нь төрийн том корпорациудад нэгдсэн байлаа. Харин 1991 оноос эдийн засгийн шинэчлэл хийж, эдийн засгийн нээлттэй бодлогыг

¹ МУИС, ОУХС-ийн дэд профессор, доктор (Ph.D)

² Д.Неру. “Ертөнцийн түүхийг сөхөн үзвэл”, УБ., 1989., 3-р боть, х.142

³ “Гурван удирдагч”. Москва., 1986., х. 22

хэрэгжүүлэн зах зээлийн харилцаанд шилжих шат дараалсан алхмуудыг хэрэгжүүлснээр эдийн засгийн өсөлт хөгжилтийн гадаад эх сурвалжийг ашиглах, гадаадын хөрөнгө оруулалтыг татах таатай орчин бүрдүүлж чадсан юм. Тухайлбал 1986-1991 онд жилд дунджаар 200 сая хүрэхгүй ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалт орж ирж байсан бол 90-ээд оны дунд үед 3 млрд гаруй болсон байна. 1999 оны сүүлчээс эдийн засгийн шинэчлэлийн хоёр дахь үеийг эхлүүлсэн бөгөөд үүний үр дүнд эдийн засгийн бүтцийн өөрчлөлт гарч хурдац эрс нэмэгджээ. Зөвхөн сүүлийн 10 жилд Энэтхэгийн аж үйлдвэр 50 хувь өссөн бол өндөр технологийн бүтээгдэхүүний экспорт 65 хувиар өссөн байна.

Энэтхэгийн ДНБ-ий хэмжээ 2008 оны байдлаар 1 005 тэрбум ам.доллар (PPP)-т хүрч, нэг хүнд ногдох ДНБ –ий хэмжээ 4 542 ам. доллар болсон нь 1,1 тэрбум гаруй хүн амтай орны хувьд маш том амжилт юм. ДНБ-д үйлчилгээ 56 хувь, хөдөө аж ахуй 22 хувь, аж үйлдвэр 22 хувийг эзэлж байна. ДНБ-ний өсөлт 2006 онд 9 хувь, 2007 онд 8,4 хувь, 2008 онд 7,8 хувь байсан бол мэдээллийн технологийн салбарын өсөлт 2007 онд 20 хувьд хүрч, экспорт 20,9 хувиар, импорт 21,6 хувь өсчээ.

Энэтхэгийг унтаж буй аврага, торонд хоригдсон бар хэмээн хошигнож эдийн засгийн жилийн 3 хувийн өсөлтийг “индус” маягийн өсөлт гэж тохуурхаж байсан үе саяхан билээ. Тэгвэл одоо Энэтхэгийг GE Capital “давтагдашгүй гайхалтай”, PepsiCo “хамгийн хурдацтай хөгжиж байгаа”, Motorola “ирээдүйн глобал эх үүсвэр” гэж тодорхойлноос харахад тус орны өнгөрсөн, одоо, ирээдүйн дүр төрх харагдахуйц байна. Тусгаар тогтнолоо олсноос хойшх БНЭУ-ын өнгөрсөн 62 жилийн ололт амжилтыг тоймлон авч үзвэл:

- улс төр, төрийн удирдлагын нарийн тогтоц, төрийн аппарат бүрэн бүрэлдсэн,
- туйлын ядуурлыг 2 дахин бууруулсан,
- хүн амын бичиг үсэг тайлалт, эрүүл мэндийн салбарт үлэмж амжилтанд хүрсэн,
- дэлхийд 3 дахь өндөр хурдацтай эдийн засаг болсон,
- ДНБ-ний хэмжээгээр дэлхийд айргийн тавд орох болсон,
- мэдээллийн технологи, “outsourcing”, харилцаа холбоо, эмийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн салбарт глобал тоглогч болсон,
- эрдэм шинжилгээний ажилтнуудын тоогоор дэлхийд гуравдугаар байранд ордог,
- дэлхийн түвшинд судалгаа шинжилгээний ажлыг явуулж буй их дээд сургуулиудаараа алдартай болсон гээд олон амжилтыг жагсааж болно.

БНЭУ-ын нийгэм эдийн засгийн өсөлт хөгжилтөд гадаадын хөрөнгө оруулалт онцгой үүрэг гүйцэтгэсэн юм. Гадаадын хөрөнгө оруулагчдыг Энэтхэг улс өсөж буй 1 млрд гаруй хүн ам бүхий асар том зах зээл, хөгжилтэй дэд бүтэц, ялангуяа R&D, санхүү, банкны салбарын хөгжил, уян хатан зохицуулалтын орчин, удирдлага болон зөвлөх үйлчилгээг дэлхийн стандартын түвшинд үзүүлж чадах өндөр мэргэшлийн боловсон хүчин, ажил хэрэгч уур амьсгал, хүчтэй шүүхийн тогтолцоо, чөлөөт хэвлэл, ажил хэргийн англи хэл, тогтвортой өсөлт, макро эдийн засгийн тогтвортой байдал, эдийн засгийн ирээдүйгээрээ татаж байна.

БНЭУ нь гадаадын хөрөнгө оруулалтыг татахаас гадна сүүлийн жилүүдэд бусад орнуудад үлэмж хөрөнгө оруулалт хийх болсон байна. Хөрөнгө оруулалтын дийлэнх хэсэг нь АНУ, Их Британи, Франц, Герман, Бельги, ОХУ, Бразили улсын газрын тос болон хийн сектор, олборлох, төмөрлөг, эмийн үйлдвэрлэл, харилцаа холбоо, химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд чиглэжээ. Зөвхөн 2007 оны 1-2 дугаар сард гадаад орнуудад Энэтхэг 23 тэрбум ам. долларын хөрөнгө оруулалт хийсэн байна.

Forbes Global сэтгүүлийн 2007 оны дугаарт Энэтхэгийн 34 компани дэлхийн 2000 хамгийн том компаниудын тоонд бичигдсэн байна. Тухайлбал Oil and Natural Gas Corporation (239), Reliance Industries (258), State bank of India (326), Indian Oil Corporation (399), Infosys Technologies, ICICI Bank, Reliance Industries, Steel Authority of India, Tata Consultancy Services,

⁴ IMF, WEO Database

Tata Steel, National Thermal Power Corporation зэрэг компаниуд нь дэлхийн глобал тоглогчдын эгнээнд орсон байна.

БНЭУ-ын шинжлэх ухааны салбарт олсон ололт амжилтыг онцгойлон дурьдмаар байна. Цөмийн шинжлэх ухаан, сансар судлал, цахим тооцоолуур зэрэг шинжлэх ухааны багтаамжтай салбарт их амжилтанд хүрсэн.

Өөрийн пуужингаар хиймэл дагуул хөөргөдөг цөөн орны нэг, биотехнологи, программ хангамжийн чиглэлд Энэтхэгийн эрдэмтдийн хийсэн ажил дэлхийн түвшинд хүрч, суперкомпьютер үйлдвэрлэх боллоо. Улс орныхоо хөгжил дэвшлийг хангахын тулд дэлхийд өрсөлдөж чадахуйц боловсон хүчнийг бэлтгэх асуудалд онцгой анхаарч ирсэн нь энэхүү салбарын ололт амжилтын нэг үндэс нь болсон байна.


Одоо дэлхийн санхүүгийн хямралыг даван туулахын тулд нэгдүгээрт, өсөлтийг илүү үр өгөөжтэй болгох, хоёрдугаарт, дэд бүтцийг түлхүү хөгжүүлэх, гуравдугаарт, урт хугацаанд тогтвортой өсөлтийг хангах чиглэлд хөтөлбөр төслүүд хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Өнөөдөр БНЭУ нь түүхий нефтийн импортоос хараат байдал, ядуурал, бүс нутгийн тэнцвэргүй хөгжил, олон сая энэтхэгчүүдийн аж амьдралтай салшгүй холбоотой хөдөө аж ахуй, нэн ялангуяа газар тариаланг хөгжүүлэх зэрэг тулгамдсан асуудлууд олон байгаа боловч нэгэнт эрч хурдаа авч, өсөлт хөгжлийн замаар цаашид ч тууштай явах нь улс орныхоо эдийн засгийн 2020 он хүртэл хөгжүүлэх дунд, урт хугацааны стратегийн чиглэлүүдийг тодорхойлсон байдлаас харагдаж байна.


Үүнд: эрчим хүч, үүний дотор атомын эрчим хүч, мэдээллийн технологийн кластер, батлан хамгаалах-аж үйлдвэрийн цогцолбор, сансар судлал, агаарын тээвэр, дээд зэргийн нарийн электроник, харилцаа холбоо, атомын аж үйлдвэр нь эдийн засгийн хөгжлийн нэн чухал тэргүүлэх чиглэлүүдээр тодорхойлогдсон байна.

Олон улсын шинжээчдийн үзэж байгаагаар 2050 онд Энэтхэг нь Хятад, АНУ-ын дараах 3 дахь том эдийн засагтай орон болох бөгөөд BRIC орнуудаас хамгийн өндөр эдийн засгийн өсөлттэй байх нь⁵.

Зураг 1



Зураг 2



Ийнхүү тусгаар тогтнолоо олсноос хойшхи БНЭУ-ын өсөлт хөгжил, ололт амжилт, ирэдүйн хөгжлийн чиг хандлага нь хөгжиж байгаа орнуудын хувьд сайхан ирээдүйд итгэх итгэл тэмүүллийг төрүүлэн, үлгэр загвар болж байна.

Бидний монголчуудын хувьд Энэтхэг орноос суралцах зүйл их байна. Манай хоёр орны хооронд 1955 оны 12 дугаар сарын 24-нд дипломат харилцаа тогтсоноор худалдаа, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаа хөгжих болсон билээ. 2009 оны 9 дүгээр сард Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж БНЭУ-д төрийн айлчлал хийх үеэр хоёр тал хамтын

⁵ "Dreaming With BRICs: The Path to 2050". GS., 2003., p.4

ажиллага, түншлэлийг гүнзгийрүүлэх чиглэлүүдийг тохирч “Иж бүрэн” түншлэлийн түвшинд харилцаагаа ахиулж хөгжүүлэх болсон нь чухал ач холбогдол бүхий алхам боллоо.

Өндөр хэмжээний айлчлалыг байнга солилцох, Энэтхэг улсын Эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны Монголд хэрэгжиж байгаа хөтөлбөрийн цар хүрээг өргөтгөх, Монгол Улсын эдийн засгийн тогтворжилтод зориулж 25 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл олгох, эрчим хүч, эрдэс баялаг, соёл боловсрол, иэдээллийн технологийн салбарт хамтран ажиллахар тохиролцов. Мөн түүнчилэн олон улсын тавцан дээр хамтран ажиллах талаар тохиролцов. Тухайлбал Ази Номхон Далайн бүс нутгийн энх тайван, тогтвортой байдалтай холбоотой асуудлууд, үүний дотор АСЕАН-ы бүсийн форум (ARF), Ази Европын уулзалт (ASEM) зэрэг олон талын бүтцэд хоёр тал хамтын ажиллагаагаа эрчимжүүлэхэд бэлэн байгаагаа дахин тэмдэглэв.

НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийг өргөтгөх үед Энэтхэг Улсыг байнгын гишүүнээр сонгохыг МУ бүрэн дэмжиж байгаагаа дахин нотлов. Хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны өргөжилт тэлэлт нь манай хоёр орны хөгжил дэвшилд өөрийн гэсэн тодорхой орон зайг бий болгох нь тодорхой.